

БАТЛАВ
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ДАРГА

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдөр

ДАРХАН-УУЛ АЙМАГТ “СОЁЛ, УРЛАГИЙН АЖИЛТНЫ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ

Үндэслэл: Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 204 дүгээр Тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдал, тэмдэглэлт өдөр”-ийн жагсаалтын 2 дугаар бүлгийн 2.32-д Соёл, урлагийн ажилтны өдрийг жил бүр 9 дүгээр сарын 2 дахь ням гарагт тэмдэглэн өнгөрүүлэхээр тус тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан.

“Түүхэн үйл явдал, ой тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 2.2-д “Салбарын болон зарим мэргэжлийн ажилтан ажилчдын өдрийг тэмдэглэх хүрээнд тухайн жилд тодорхой сэдэв уриан дор дараах арга хэмжээг зохион байгуулж болно”, 2.3-д Тэмдэглэлт өдрийг тэмдэглэх асуудлыг тухайн байгууллага үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвтөө тусган батлуулж, зардлын гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллана” хэмээн заасан.

Зорилго: Соёл, урлагийн ажилтны 31 дэх өдрийг тохиолдуулан Соёлын салбарын ажилтнуудын түншлэл хамтын ажиллагаа, нийгмийн хариуцлага, манлайллыг өргөх, соёлын байгууллага, соёлын ажилтнуудын онцлог, үйл ажиллагаа, ололт амжилтыг олон нийтэд мэдээлж, сурталчлах, салбарын ажиллагсдын хөдөлмөр, бүтээлийг тодруулан алдаршуулах, иргэдэд соёлын олон талт үйлчилгээ үзүүлэх, тэдний санал, хүсэлтийг сонсох, бүтээлч ажил, үйл ажиллагаанд оролцуулахад оршино.

Хамрагдах байгууллага, уран бүтээлчид: Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Залуучууд театр, Аймгийн Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Хонгор сумын Соёлын төв, Орхон сумын Соёлын төв, Шарын гол сумын Соёлын төв, МСНЭ-ийн Дархан салбар, Нарыг хайрла “Хойд бүсийн гэрэл зурагчдын холбоо”, Зураач, урчуудын холбоо, МЗЭ-ны Дархан салбар зөвлөл, ЕБС, Их дээд сургуулийн номын санчид, Бүжгийн холбоо, Дархан хотын чөлөөт уран бүтээлчид, СББӨ-ийг өвлөн уламжлагчид, 330-р ангийн хөгжмийн салаа болон Дархан-Уул аймгийн иргэд тус тус хамрагдана.

Зохион байгуулах үйл ажиллагаа, хугацаа: Соёл, урлагийн ажилтны өдрийг 2024 оны 09 дүгээр сарын 09-нөөс 9 дүгээр сарын 14-ний өдрүүдэд дараах 3 чиглэлээр тэмдэглэн өнгөрүүлнэ. Үүнд:

➤ **Соёлын байгууллага, соёлын ажилтны онцлог, үйл ажиллагааг сурталчилсан боловсролын хөтөлбөр:**

Соёл, урлагийн ажилтны өдрийг тохиолдуулан 2024 оны 09 дүгээр сарын 09, 10-ны өдрүүдэд тус газрын харьяа соёлын байгууллагууд нь иргэд, олон нийтэд чиглэсэн соёлын боловсролын олон хөтөлбөрийг нээлттэй зохион байгуулж соёлын байгууллага, соёлын ажилтныг сурталчлан таниулна.

Зохион байгуулсан соёлын боловсролын хөтөлбөр, үйл ажиллагааны тайланг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Соёл, гэгээрлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Долгормаад /99393046/ 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн дотор ирүүлнэ.

➤ **Спортын бага наадам:**

Соёлын салбарын ажилтан, албан хаагчдын дунд дараах 5 төрлийн спортын тэмцээнийг аймгийн Дархан сумын 4 дүгээр багт байрлах Дархан сумын ЗДТГ-ын Спорт зааланд тусгай удирдамжийн дагуу 2024 оны 09 дүгээр сарын 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулна. Үүнд:

1. Сагсан бөмбөг /холимог баг/
2. Гар бөмбөг /холимог баг/
3. Теннис /эр,эм/
4. Шатар /эр,эм/
5. Дартс /Холимог баг/

Спортын тэмцээн нь 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 09:00 цагт эхлэх бөгөөд тэмцээний нээлт 14:00 цагт болно.

Техникийн зөвлөгөөнийг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 16:00 цагт аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт зохион байгуулна.

Тэмцээнд Соёл, урлагийн салбарын ажилтан, албан хаагчид, чөлөөт уран бүтээлчид, соёл, урлагийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж төрийн бус байгууллагууд, СББӨ-ийг өвлөн уламжлагчид оролцоно. Гаднаас мэргэжлийн тамирчид оролцуулахгүй.

Оролцогч байгууллагууд мандатын 300,000 /зуун мянган/ төгрөгийг 2024 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр техникийн зөвлөгөөнд ирэхдээ бэлэн авчирч хураалгана.

Спортын тэмцээнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг Хонгор сумын Соёлын төвийн дарга Г.Сайхансанаа /99976671/-наас тодруулна.

Соёл, урлагийн ажилтнуудыг чадавхжуулах сургалт:

Соёлын салбарын Залуучуудын хөгжлийн зөвлөлөөс 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 19:00 цагт Соёлын салбарын ажилтан, албан хаагчдын дунд “ЗАЛУУ МАНЛАЙЛАЛ” чадавхжуулах сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу “Эрэл” амралтын газар зохион байгуулна.

Сургалтаар соёлын салбарын ажилтан, албан хаагчдын эрүүл амьдралын хэв маягийн талаарх лекц, судалгааг тодорхойлох, нөхөрсөг харилцааг үүсгэн, тэдний ур чадварыг хөгжүүлэхэд туслах, алсын хараа, мөрөөдөл, зорилгоо оновчтой тодорхойлох, цаг баримталж өөртөө итгэлтэй, амжилттай байх, сайн иргэн, сайн эцэг эх, сайн боловсон хүчин болоход туслах арга замуудын талаарх мэдээллийг бодит үр дүнд суурилан зохион байгуулна.

Тус сургалт, үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Залуучууд театрын маркетингийн менежер, ССЗХЗ-ийн тэргүүн Ц.Баттөмөр/99120435/ -өөс тодруулна.

УДИРДАМЖ БОЛОВСРУУЛСАН:
СОЁЛ, ГЭГЭЭРЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Б.Долгормаа* Б.ДОЛГОРМАА